

Дундговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын статистик мэдээний товч танилцуулга

2021.12.01

А. Бага, дунд боловсрол

2021-2022 оны хичээлийн жилд ЕБС-ын 19 сургуулийн 343 бүлэгт 8594 сурагч суралцаж байна.

Бүлэг дүүргэлтийн дундаж 25,1 бөгөөд бага ангид 26.5, дунд ангид 24.3, ахлах ангид 22.4 байна. Хамгийн их (37) бүлэг дүүргэлт нь Мандал сургуулийн бага ангид байна, хамгийн бага (9-р анги) бүлэг дүүргэлттэй Цагаандэлгэр сумын сургууль байна. Нэгдүгээр ээлжний 288 бүлэгт 6958 хүүхэд 2 дугаар ээлжний 55 бүлэгт 1636 хүүхэд хичээллэж байна.

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Бүлэг дүүргэлт	29.2	26.7	26.7	25.1	24.3	25.2	25.6	23.6	23.0	23.6	21.3	22.2

Нэг. Сургуулийн бүтэц:

Энэ хичээлийн жил 12 жилийн 8, 9-н жилийн 11 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Хэв шинжээр нь авч үзвэл:

- Ердийн 16
- Гүнзгийрүүлсэн 1
- Цогцолбор сургууль 2 байна.

Суралцагчийн тоогоор авч үзэхэд хамгийн олон сурагчтай нь 12 жилийн Эрдмийн далай цогцолбор сургууль сургууль 1598, хамгийн цөөн сурагчтай нь Цагаандэлгэр сумын 9-н жилийн сургууль 93 хүүхэдтэй хичээллэж байна.

Бүлгийн тоо:

Бүлгийн тоо, /ангиар/												
Бүгд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
343	34	33	33	31	31	30	34	34	33	17	17	16

Дотуур байр: Нийт 17 сургуулийн 19 дотуур байртай.

Дотуур байранд суух саналтай хүүхдийн тоо	Дотуур байранд сууж буй хүүхдийн тоо	Үүнээс: малчдын хүүхдийн тоо	Дотуур байранд суух саналтай хүүхдээс дотуур байранд амьдараг хүүхдийн эзлэх хувь	Дотуур байранд суудаг хүүхдээс малчдын хүүхдийн эзлэх хувь
714	699	590	97.8	84.4

Дотуур байранд амьдрах хүсэлт 714 хүүхэд гаргаснаас 699 амьдарч /үүнээс эмэгтэй 373/ өмнөх жилээс 92 хүүхдээр буурсан. Нийт дотуур байрны хүүхдийн 84,4%-ийг малчдын хүүхэд эзэлж байна. Эрдэнэдалай сумын хүүхэд 100, Эрдмийн далай цогцолбор сургууль 69 буюу хамгийн их хүүхэдтэй, Цагаандэлгэр сумын 9 жилийн сургууль хамгийн цөөн буюу 17 хүүхэдтэй байна.

100-аас дээш хүүхдийн багтаамжтай дотуур байртай сургуулиуд:

Сум, сургуулийн нэр	Дотуур байрны хүчин чадал	Дотуур байрны сурагчдын тоо
Эрдэнэдалай	150	100
Эрдмийн далай цогцолбор	240	69
Сайхан-Овоо	100	38

Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2-р дотуур байранд хүүхэд авахад хүндрэлтэй засвар үйлчилгээ шаардлагатай нөхцөлд байгаа тул хүүхэд аваагүй.

Хоёр. Суралцагчид:

2021-2022 оны хичээлийн жилд ЕБС-д 8594 /Үүнээс эмэгтэй 4288/, хүүхэд суралцаж байгаа нь өмнөх жилийнхээс 137-аар өссөн байна.

Бүгд	сурагчдын тоо /ангиар/											
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
8594	992	881	882	779	754	757	871	801	759	401	362	355

Нэгдүгээр ангид нийт 992 хүүхэд суралцаж байгаагаас 981 хүүхэд шинээр элсэн оржээ. Үүнд 6 настай 949, 7 настай 41, 8 настай 2, элсэн орсон байна. 7 настай 41 хүүхэд 72 сар гүйцээгүй шалтгаанаар 2020-2021 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдсан 922, завсардагчаас 11 сурагч орж ирсэн байна.

Нэгдүгээр ангид элсэгчдийн 922 буюу 92,9% нь СӨБ-д хамрагджээ.

Тухайн аймгийн 6 настай хүүхдийн /хүн амын тоогоор/ 92,5 хувь нь өөрийн аймгийн ЕБС-иудад сургуульд элссэн байна. Сургуулийн гадна байгаа 6 настай хүүхэд 5 хүүхэд байна.

Өнгөрсөн хичээлийн жилд IX ангийг 629 хүүхэд төгсөж, XII ангийг 458 хүүхэд төгссөн байна. X ангид 401 хүүхэд элсэн орсон байна.

Сурагчдын хүйсийн харьцаа:

	Бүгд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Бүгд	8594	992	881	882	779	754	757	871	801	759	401	362	355
Эмэгтэй	4298	508	399	420	389	373	347	439	405	347	227	228	216
Нийт сурагчдад эмэгтэй сурагчийн эзлэх хувь	50.0	51.2	45.3	47.6	49.9	49.5	45.8	50.4	50.5	45.7	56.6	63.0	60.8

Нийт суралцагчдад эмэгтэй сурагчдын эзлэх хувь бага ангид 48.7%, дунд ангид 48.2%, ахлах ангид 60.0 хувийг эзэлж байна.

Бүтэн өнчин 18, хөгжлийн бэрхшээлтэй 77 /харах эрхтний согог 17, сонсох 3, хэл ярианы 7, оюун ухааны 13, бие эрхтний 11, хавсарсан 26 суралцагч сурч байна.

Орой эчнээ ангиар суралцаж байгаа хүүхэд байхгүй бөгөөд дүйцсэн хөтөлбөрөөр 66 хүүхэд сурч байна. Гүнзгийрүүлсэн сургалттай бүлэгт математикийн 419 хүүхэд суралцаж байгаа. Сургуулийн гадна байгаа 6-14 насны 15 хүүхэд байна.

ЕБС-д суралцаж буй сурагчдыг үндсэн захиргаагаар нь авч үзвэл Дундговь аймгийн 8316 аймгийн бус 278 хүүхэд байгаагаас хамгийн их нь УБ 157, Өмнөговь аймгийн 29 байна. Дундговь аймгаас өөр аймаг хотод нийт 320 сурагч сургуульд хамрагдаж байна.

Гурав. Багш, ажилчид:

2021-2022 оны хичээлийн жил ЕБС-д захирал 19, сургалтын менежер 32, нийгмийн ажилтан 21, албан бусын арга зүйч 17, үндсэн багш 531 багш, ажиллагсад 322 нийт 978 хүн ажиллаж байна.

Ажиллагчид /үйлчилгээний ажиллагсадаас бусад	2009- 2010	2010- 2011	2011- 2012	2012- 2013	2013- 2014	2014- 2015	2015- 2016	2016- 2017	2017- 2018	2018- 2019	2019- 2020	2020- 2021	2021- 2022
Бүгд	594	598	596	594	592	590	628	621	630	618	639	642	656
Үүнээс:	Захирал	18	19	19	18	18	18	19	19	19	19	19	19
	Сургалтын менежер	26	26	27	27	27	28	31	31	30	30	31	32
	Нийгмийн ажилтан	18	18	18	18	18	18	19	19	19	20	21	21
	Үндсэн багш	486	486	485	484	482	486	519	508	518	505	522	531
	үүнээс: бага	167	167	161	153	149	153	173	175	174	166	162	167
	Дунд	242	220	234	236	239	237	252	251	248	239	264	229
	Ахлах	77	99	90	95	94	96	94	82	96	100	96	130
	Албан бусын	15	15	15	15	15	10	10	15	15	15	15	17
	Байрны багш	19	20	18	18	18	18	18	17	16	17	17	20
	Эмч	12	14	14	14	14	12	12	12	13	12	15	13

Энэ хичээлийн жилд ажиллавал зохих 539 багшаас 531 үндсэн багш /үүнээс эмэгтэй 445/ ажиллаж байна.

Багш нарын боловсролын түвшин:

- Магистр 55 буюу үндсэн багшийн 10.4 хувь
- Бакалавр 436 буюу үндсэн багшийн 82.1 хувь
- Диплом 40 буюу үндсэн багшийн 7.5 хувь

Багш нарын насны ангилал:

- 30 хүртэл настай 151 буюу үндсэн багшийн 28.4 хувь
- 30-39 настай 244 буюу үндсэн багшийн 46 хувь
- 40-49 настай 96 буюу үндсэн багшийн 18.1 хувь
- 50-59 настай 35 буюу үндсэн багшийн 6.6 хувь
- 60-аас дээш настай 5 буюу үндсэн багшийн 0.9 хувь

Багш нар ажилласан жилээр:

- Анхны жилдээ ажиллаж байгаа 29 буюу үндсэн багшийн 5.5 хувь
- 1-5 жил 126 буюу үндсэн багшийн 23.7 хувь
- 6-10 жил 140 буюу үндсэн багшийн 26.3 хувь
- 11-15 жил 105 буюу үндсэн багшийн 19.8 хувь
- 16-20 жил 62 буюу үндсэн багшийн 11.7 хувь
- 21-25 жил 29 буюу үндсэн багшийн 5.5 хувь
- 25-ээс дээш жил 40 буюу үндсэн багшийн 7.5 хувь

Багш нарын мэргэжлийн зэрэг:

- Зөвлөх- 9 буюу үндсэн багшийн 1.7 хувь
- Тэргүүлэх – 75 буюу үндсэн багшийн 14.1 хувь
- Заах аргач - 187 буюу үндсэн багшийн 35.2 хувь нийт зэрэгтэй багш нь үндсэн багшийн 51.0 хувийг эзэлж байна.